

СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН ТАЙЛАН

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:

2022 оны 10 сард албан хэрэг хөтлөлтийн явцад зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийг бүрдүүлж, зааврын дагуу хөтөлж, дээд газраас ирж буй албан бичиг эрхийн актыг хүлээн авч, бүртгэн удирдах албан тушаалтанд танилцуулж, холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлж, шийдвэрлэлтийн хугацаа, биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

-10-р сарын байдлаар дээд газраас 36 нийт албан бичиг ирснээс, хариутай бичиг 11 ирж, 7 албан бичгийн хариуг хугацаанд нь барагдуулж, хугацаа болоогүй 4 албан бичиг байна.

-Мөн нийт 9 эрх зүйн баримт бичиг ирснээс Аймгийн Засаг даргын Захирамж 5, Аймгийн Засаг даргын албан даалгавар 2, Аймгийн БОАЖГ-ын даргын албан даалгавар 1, Монгол улсын БОАЖ-ын сайдын албан даалгавар 1 ирж хэрэгжиж байна. -Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргаж дотоод чатад тавьж мэдээлж ажиллаж байна.

Дотоодын ажлын талаар:

2022 оны 10-р сарын байдлаар;

- 1.Сумын Засаг даргын А-Захирамж – 13
- 2.Сумын Засаг даргын Б-Захирамж - 7
- 4.Засаг даргын албан бичиг -14
- 5.ЗДТГ-ын даргын А-Тушаал - 3
- 6.ЗДТГ-ын даргын Б-Тушаал - 2
- 7.ЗДТГ-ын даргын албан бичиг - 10

Өргөдөл гомдлын талаар:

2022 оны 10-р сарын байдлаар иргэдээс Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 6 өргөдөл гомдол ирснээс шийдвэрлэгдсэн 4, хугацаа болоогүй 2, шийдвэрлэлтийн хувь 66,6%.

Архивын ажлын талаар:

- ☐ Архивын данс бүртгэлийг шинэчлэн, Төрийн архивт 2011-2016 оны баримтыг цахим болон цаасан хэлбэрээр тушаахаар тоо бүртгэлийн ажил хийгдэж эхлээд байна.
- ☐ 10 сарын байдлаар архиваас 5 иргэн, албан тушаалтанд нийт 16 хадгаламжийн нэгжийг ашиглуулж, лавлагаа хуулбарыг олгосон байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Үндсэн ажлын хүрээнд:

Нийт үзлэг-134

Урьдчилан сэргийлэх-57

Амбулаторт-67

Артерийн гипертензин эрт илрүүлэг-37

Чихрийн шижин эрт илрүүлэг-37

жирэмсний хяналтанд байгаа-15

Шинээр хамрагдсан-2

Жинэлсэн хүүхдийн тоо-165

Эмнэлэгт хэвтсэн-335

Холын дуудлага-6

Төвийн дуудлага-66

Дусал тариа-233

Судас тариа-426

Булчин тариа-61

Арьсан доорх тариа-16

Уян зүү-1

Боолт-24

Сэргээн засах:

Нил улаан туяа-13

Хэсэгчилсэн зөөлөн бариа-13

Утлага-6 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна

Лаборатори:

Шээсний шинжилгээ-13

В,С вирусын шинжилгээ-15

ДОХ,Тэмбүү шинжилгээ-2

Сахар-12

Covid-33

Сургалт сурталчилгаа

Олон нийт руу чиглэсэн:

Жил бүрийн 09сарын 30ны өдрийг Зүрхний өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Энэ жил “Эрүүл зүрхний төлөө хамтдаа” нэртэйгээр зохион байгуулж буйтай холбогдуулан ЕБС-ийн Доржханд багштай 5р ангийн сурагчдад

“Зүрх гэж юу вэ”?

Зүрх юунд дуртай вэ?

Зүрх юунд дүргүй вэ? талаар харилцан ярилцаж аянд нэгдсэн.



“Дэлхийн Гар угаах” өдрийг тохиолдуулан дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулсан:

- Наран Сум Хүүхдийн Цэцэрлэг-ийн “Бэлтгэл” бүлгийн 38 хүүхдүүдэд “Гар юунаас болж бохирддог” талаар харилцан ярилцаж гар угаах дадал хэвшлийг бататгалаа.



ЕБС-ийн 2а ангийн 24 сурагчдад

“Гар юунаас бохирддог вэ?” сэдэвт сургалтыг зохион байгуулж, Өөрсдийн цэвэр гараар постер хийж, “Гар угаах дарааллаар бүжиг” хийж өөрсдөдөө дадал хэвшлийг олголоо.



Эмчилгээний хоолны 45 хонгийн аяны хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан.
 “Өглөөний цайг өөртөө” арга хэмжээг зохион байгууллаа.
 Сургалтаар
 “Эрүүл зөв хоололт”
 “Эмчилгээний хоол гэж юу вэ?”
 “Антибиотик эмийн зөв зохистой хэрэглээ” сэдэвт сургалтуудыг зохион байгуулав.
 Хүрэлцэн ирсэн 15 иргэдэд “дархлаа сэргээх багц” олгов.



БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

БНСУ-ын Жусан бага сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд Солонгосын соёлын илгээмжийг таниулах түгээн дэлгэрүүлэх "Талархалын өдөр" арга хэмжээ

Л.Чинзориг багштай 4 ангийн суралцагчид, эцэг эхчүүдийн хамт амжилттай болж өнгөрлөө.



“Ази-Номхон далайн бүсийн багш солилцооны хөтөлбөр”-ийн хүрээнд Солонгос улсын Жусан бага сургуулийн 5 ба 6-р ангид "Монгол үндэсний хувцас" хичээлийг Э.Оюунтунгалаг, Л.Чинзориг нар цахимаар зохион байгууллаа.



“Залуу багийн чадваржуулах” ур чадварын хөтөлбөрийн хүрээнд О.Мөнхзул багш түрүүлж, өөрийн аргазүй туршлагаа хамт олондоо түгээн дэлгэрүүлэн 7-р ангид математикийн үзүүлэх хичээлийг амжилттай зохион байгуулж заалаа.

ЭЦЭГ ЭХИЙН БҮТЭЭЛЧ ӨДРҮҮД:

Багш, эцэг эх, суралцагчдын хамтын ажиллагааг дэмжих, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх, сургуулийн хичээл, өдөр тутмын үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах зорилгоор эцэг эхийн нээлттэй өдөрлөгийг дундын заах аргын нэгдэлийн Байгалийн ухааны судлагдахууны баг сургуулийн захиргаатай хамтарч амжилттай зохион байгууллаа.

Өдөрлөгт 10 бүлгийн 100 гаруй эцэг эх асран хамгаалагчид ирж сургуулийн нэг өдрийн хичээл сургалтын үйл ажиллагаатай танилцлаа. Өглөө 09:-9:30 минутанд бүртгэл эхэлж, эцэг эхчүүд багш нарын хичээлд сууж ажиглалт хийх, "Хөгжөөнт буухиа" тэмцээнийг зохион байгуулж, үдийн хойно 14:00 цагаас 2022-2023 оны хичээлийн жилийн эцэг эх асран хамгаалагчдын нэгдсэн хуралыг зохион байгуулж дараах сэдвээр сургуулийн удирдлагууд мэдээлэл хийлээ. Үүнд:

1. Сургуулийн зорилго, зорилт
2. Сургалт, хүмүүжийн үйл ажиллагаа болон эцэг эхчүүдийн esis программд хандах дадлага ажил
3. Хүүхэд хамгааллын бодлого, хэрэгжилт, үр дүн
4. Сурах бичгийн хүрэлцээ хангамж, ашиглалт
5. "Үдийн цай" хөтөлбөрийн амталгаа
6. БСШУСС-ын 2019.12.17-ны А803 тушаалын хэрэгжилт

7. Сургуулийн эцэг эхийн нэгдсэн зөвлөл байгуулах зэрэг ажлуудыг хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгууллаа.

Мөн эцэг эх, асран хамгаалагчдаас энэ хичээлийн жилд сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг хэрхэн сайжруулах, багшийн ёс зүй, харилцаа хандлага, орчны эрүүл ахуй зэрэгт үнэлгээ дүгнэлт өгөх, санал санаачлагыг нь сонсох зорилгоор нээлттэй санал асуулга авч ажилласан.



Сургууль, багш, эцэг эх асран хамгаалагчдын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хүүхдийн суралцах үйлийг дэмжих зорилгоор Багш нарын баярын өдөр М.Ганболор багштай 36 анги

"ЭЦЭГ ЭХИЙН ХИШИГ ӨДӨР"-ийг зохион байгуулж, тухайн өдрийн бүхий л сургалтыг хөтлөн явуулж, хичээл заан, хүүхдүүддээ цаг гарган, тэдэнд сурагч насны нэгэн тод дурсамж бүтээлцэж өгсөн сайхан үйл ажиллагаа болж өнгөрсөн.



2022-2023 оны хичээлийн жилд сургуулийн "ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ" анхны хуралдаанаа хийж хэрхэн яаж хамтарч ажиллах талаар санал бодлоо солилцож төлөвлөгөө гаргаж ажиллалаа.



АЖЛЫН БАЙРАН ДЭЭР СУРГАЛТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ:

2022. 10.10-12 ны хооронд БШУЯ, Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн дэмжлэгээр зохион байгуулсан “Явцын

үнэлгээний өгөгдөлд суурилсан бага ангийн суралцагчдын унших болон математик чадварыг дэмжих арга зүй” сэдэвт сургалтанд үндэсний сургагч багшаар C\Менежер бэлтгэгдэж мэргэжил арга зүйгээ дээшлүүлж ажилласан.

Багш нь Амьдрах ухааны боловсрол цахим сургалтад хамрагдаж мэдлэг арга зүйгээ дээшлүүлж ажилласан.

БШУГ-аас "Үе тэнгийн дээрэлхэлтийн сарын аян"-ы хүрээнд зохион байгуулах цаг үеийн мэдээллийн сургалтанд НА-тан хамрагдаж сургуулийн орчинд хэрхэн үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр мэдээлэл авч ажилласан байна.



2. ХӨГЖИЛ-ХАМГААЛАЛ-ОРОЛЦОО:

Суралцагчдыг бүтээлч хөдөлмөрт сургах, зуны

амралтыг нь зөв боловсон өнгөрүүлэх, гэр бүлд ээ туслах зорилгоор зохион байгуулагдсан “Зуны зугаатай амт” үзэсгэлэн худалдааг 9 анги бүлгийн суралцагчдын дунд зохион байгуулж, хөдөлмөрийн аварга ангиудыг шалгарууллаа. Хөдөлмөрийн аварга анги хамт олноор:

Бага анги:1- р байр С.Энхжаргал багштай 2а анги,

2-р байр Л.Чинзориг багштай 4а анги

Дунд анги: 1-р байр Л.Болормаа багштай 8а анги

2-р байр О.Ганчимэг багштай 7а ангиуд эзэлсэн.



Суралцагчид бие биенээ болон багшийг хүндэтгэх, багш мэргэжлээр бахархах үзлийг төлөвшүүлэх, мэргэжлээ зөв сонгох арга зүйд суралцах зорилгоор



Л.Сугар багштай 9а ангийн хамт олон сургуулийн захиргаатай хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Үүнд:

“Багш болох сайхан” хичээл үйл ажиллагааны нээлтийг 07:30 минутанд хийж, багш болсон суралцагчдад хичээл үйл ажиллагаанд нь амжилт хүсэж мэндчилгээ дэвшүүлсэн.

Багш нарыг 1 танхимын суралцагчид болгож, англи хэл, дуу хөгжим, биеийн тамирын хичээлүүдийг 9-р ангийн сурагч Ч.Нандин-Эрдэнэ, М.Энхсайхан, М.Хүслэн нар зааж зохион байгуулсан.

С\Захирал М.Энхсайхан, С\менежер А.Ариунзаяа, НА-тан Х.Хосбаяр нар багш болсон суралцагчдын хичээл үйл ажиллагаанд сууж, ажиглалт дүгнэлт хийж шилдэг арга зүй, эв дүйтэй башгийг шалгаруулахад англи хэл, биологийн багш болсон Ч.Нандин-Эрдэнэ шалгарлаа.

12:30 минутаас хичээл үйл ажиллагааны дүгнэлтийг суралцагч нэг бүрээр сэтгэгдэлийг нь яриулж дүгнэлт хийлээ.



Багш нарын баярын өдрийг угтан төдөвлөгөөний дагуу дараах үйл ажиллагааг сургуулийн захиргаатай зохион байгуулж явууллаа. Үүнд:

- Нийт сургуулийн ахмад, багш ажилчдад багш нарын баярын хүндэтгэлийн үйл ажиллагаанд оролцох урилга хийж тараах ажлыг зохион байгууллаа.
- 2022.10.05-ны өдөр сургууль, цэцэрлэгийн багш нарын дунд “Хөгжилтэй буухиа” тэмцээнийг сургуулийн захирал, биеийн тамирын багтай хамтран зохион байгуулж явуулахад нийт 6 баг амжилттай оролцлоо. Мөн нийт багш ажилчдын дунд “Онч мэргэн” харвааны тэмцээнийг зохион байгуулж эрэгтэй, эмэгтэй шилдэг харваачдыг шалгаруулж шагнаж урамшуулсан.
- 2022.10.06-ны 15 цагт “Багшийн алдар” хүндэтгэлийн хурлыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. 16:00 цагаас “Багшаа дуулья” суралцагчдын тоглолтыг хөтөлбөрийн дагуу хөтөлж, хөгжмийн багштай хамтран зохион байгуулсан.
- Орой 19:00 цагаас залуу багш нартай хамтран үдшлэгийг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, хамгийн хамгийн багш нараа шалгаруулсан.



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей 2012 оноос эхлэн жил бүрийн 10 дугаар сарын 11 ний өдрийг Олон Улсын Охидын Өдөр болгон тунхагласан. Дэлхийн 193 оронд энэ өдрийг Олон Улсын Охидын Өдөр буюу Олон Улсын Охидын эрхийг хамгаалах өдөр болгон тэмдэглэж байгаа юм. Энэ жилийн охидын өдрийн ёс зүйн жилийн хүрээнд “Бадмаараг” охидын клубын сурагчид, чиглүүлэгч багш Б.Баасанжав нартай хамтран үйл ажиллагаануудыг хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Үүнд:

- 2022.10.10-наас 10.11-ны 17 цаг хүртэл “Хайрлаж хүндэлдэг охидод илгээх захидал”-ын аяныг сургууль дээрээ өнгөрүүлж, сургуулийн захирал ОУ-ын “Охид”-ын

өдрийг угтан мэндчилгээ дэвшүүллээ. Мөн охидод ирсэн сэтгэлийн илгээмжийг хүргэх, гардуулах ажлыг зохион байгуулсан.



Сүхбаатар аймгийн Хүүхдийн өөрийн удирдлагын болон хөгжил оролцооны байгууллагуудын "НЭГДҮГЭЭРТ- ХҮҮХЭД" сүхбаатар аймгийн хүүхдийн чуулганд сурагчдыг төлөөлөн 6а ангийн сурагч О.Баярсайхан, 7а ангийн сурагч Ч.Базаррагчаа, 8а ангийн сурагч Б.Хонгорзул, 9а ангийн сурагч Э.Номин, Ч.Нандин-Эрдэнэ нар сургуулийн нийгмийн ажилтан, сумын хүүхдийн зөвлөлийн тэргүүн Засаг дарга Л.Оч нарын бүрэлдэхүүнтэй оролцлоо. Оролцогч хүүхдүүд маань

- ✚ Чуулганд оролцож буй хүүхдүүдийн төлөөлөл болж мэндчилгээ дэвшүүлэх
- ✚ Сумын онцлог болон тэдэнд тулгамдаж буй асуудлаар 3 минутын видео бичлэг бэлдэж оролцох асуудлаар 9а ангийн сурагч Э.Номин, Ч.Нандин-Эрдэнэ нар суралцагчдын биеийн тамирын талбайн асуудал буюу хүүхэд хөгжлийн танхимтай болох асуудал тавьж хэлэлцүүлсэн.
- ✚ Оролцогч хүүхдүүд, төлөөлөгч нарт урлагийн номер үзүүлэх зэрэг үйл ажиллагаагаар оролцож байна. 2022.10.13



Хүүхдийн хөгжил оролцоог хангах хүүхдийн өөрөө удирлагын байгууллагуудын болон суралцагчдын өмнө тулгамдаж буй асуудал, санал бодлыг сумын үүрэг хүлээгчдэд хүргэх, "Хүүхдийн зөвлөл"-ийг шинэчлэн байгуулах зорилгоор зохион байгуулагдсан сумын хүүхдийн "НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД" 6-р чуулганыг хөтөлбөрийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 14-18 цагийн хооронд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Чуулганд нийт 140 гаруй төлөөлөл оролцсон болно.

Чуулганаар:

1. Хүүхэд хамгааллын 5-н хэлбэрийн хүрээнд суралцагчдыг 5 бүлэгт болгож, Салбар дундын хэлэлцүүлэгийг зохион байгуулж, тухайн сэдвийн хүрээнд орон нутагт тулгамдаж буй асуудлыг хөндөн удирдах түвшинд танилцуулснаар хүүхдийн өмнө үүрэг хүлээгч орон нутгийн удирдлагууд шат шатандаа шийдвэрлэж ажиллахаа #АМЛАСАН юм. Үүнд:



Сумын ЭМТ-ийн их эмийн үүрэг гүйцэтгэгч М.Урангоо анги бүрт “Анхны тусламж”-ийн иж бүрэн хайрцаг байршуулахаа амласан. Улирал тутам эмчийн үзлэгийг чанартай зохион байгуулж, шүд эрүүлжүүлэх талаар мэргэжлийн эмчийг авчирж үйлчилгээ үзүүлж ажиллах санал хүсэлтээ илэрхийлж оролцлоо.

Сумын хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн, засаг дарга Л.Оч айл өрх бүр, албан байгууллага бүрийг сагсаны шийдтэй болох асуудалд хариулт өгч эхний ээлжинд 20 голцоо шийдвэрлэж өгөхийг амлаж ажилласан.

Суралцагчдын хөгжил оролцоог нэмэгдүүлэх, авьяас чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ЕБС-д 20 мандилин хөгжим авч өгөхөөр шийдвэрлэв.

Сумын хэмжээний суралцагчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх “Кофе шоп”-ыг байгуулах

2023 оны орон нутгийн төсвөөр хүүхдийн цэцэрлэгт хүрээлэн буюу тоглоомын талбайг сайжруулж ажиллах талаар амлалт өглөө.

2022-2023 оны хичээлийн жилд зохион байгуулагдах “Урлагийн наадам”-ийн 3-н төрлийг ЗДТГ-ийн нөөц сангаас ивээн тэтгэхээр болсон.

Сургуулийн захирал Ө.Боргил сургуулийн гадна талбайн гэрэлтүүлэг, машины болон дугуйн зогсоол, жагсаалын талбайг ойрын хугацаанд хийж ажиллах,

ЗД-ын орлогч Ч.Идэрчулуун төв тоглоомын талбайд “Интернет орчин”-г бий болгох, зөв зохистой ашиглах,

Сумын удирдлагууд чуулганд оролцогч хүүхдүүд, багш нарын өмнө дээрх бүтээн байгуулалтын ажлуудыг 2023-2024 онуудад хийхээр төлөвлөж, танилцуулж ажилласан.

2. Төрийн байгууллагын эрхэм удирдлагууд мэндчилгээ дэвшүүлж, чуулганы үйл ажиллагаанд амжилт хүслээ.

3. Сумын "ХҮҮХДИЙН ЭЛЧ"-ийг сонгох хүндэтэй бөгөөд хариуцлагатай сонголтод суралцагчид 3 нэр дэвшигчдэд саналаа өгч 45 хүүхдийн саналаар СӨБ-ийн эрхлэгч Ж.Хүрэлчимэг сонгогдлоо. Сонгогдсон хүүхдийн элчээр “Андгай”-г уншуулж санал бодлыг нь сонсож батламж гардуулан өгсөн.

4. Сурагчдын санал хураалт, сонголтоор Ч.Нандин-Эрдэнэ тэргүүнтэй сумын ХҮҮХДИЙН_ЗӨВЛӨЛ-ийг шинэчлэн 11 хүүхдийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллалаж тэдний санал санаачлага, дуу хоолойг сонсож ажилласан.


5. Бага ангийн авъяаслаг хүүхэд багачууд маань мэндчилгээ дэвшүүлж чуулганы сэтгэгдэлээ илэрхийлж оролцсон.



Наран суманд хүүхэд багачууд чуулсан энэ баясгалантай өдөр гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг ажилладаг “Хамтарсан баг” өрөөтэй болж, өрөөнийхөө нээлтийг хийн сумын удирдлагуудад танилцуулж ажилласан.



БЕГ-аас зохион байгуулж буй "Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх" сарын аяны төлөвлөгөөг боловсруулан гаргаж, ангийн нийт сурагчид болон дотуур байрны сурагчдад сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж, "БИД ДЭЭРЭЛХЭХГҮЙ" аянд анги хамт олноороо уриалга гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн дотуур байрны сурагчдад сургалтыг хуваарийн дагуу зохион байгууллаа.



ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Малчид, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллийг олон нийтэд танилцуулах, үйл ажилгааг нь дэмжин хөгжүүлэх, харилцан туршлага солилцуулах зорилгоор Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл-2022 арга хэмжээний хүрээнд Эрүүл хүнс, Алтан намар, Сүхбаатарт үйлдвэрлэв, Шилмэл мал үзэсгэлэн худалдаа 2022 оны 09 дүгээр сарын 28,29-ний өдрүүдэд Баруун-Урт суманд болсон уг арга хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцсон байна.

Шилдэг оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгч номинацад **АДУУЧИН МАЛГАЙ БРЭНД** дэд байр

ЦАГААН ИДЭЭ онцлох бүтээгдэхүүнээр шалгарсан байна



Тогооч нарын ур чадварын тэмцээнд оролцсон тухай мэдээлэл 2022 оны 10 дугаар сарын 17 Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх, хоол үйлдвэрлэлийн салбарыг шинэ шатанд гаргах, боловсон хүчнийг чадавхжуулах, нийтийн хоолны соёлыг сурталчилан таниулах, хөгжүүлэх “Дэлхийн хүнсний өдөр”-ийг угтан зохион явуулсан Сүхбаатар аймгийн аварга тогооч, зөөгч шалгаруулах тэмцээнд Наран сумын төсөвт байгууллагын тогооч нар 10 хүний бүрэлдэхүүнтэй баг оролцож дараахь амжилтыг үзүүллээ.

- 2023 оны “Зүүн болон Говийн бүс-ийн аймгуудын тогооч нарын ажил мэргэжлийн ур чадварын тэмцээнд оролцох “ЭРХ”-ийн бичгээр шагнагдав.
- Сумдын дунд зохион байгуулсан Урлагийн тэмцээнд 3-р байр эзэлж хүрэл медаль





“Малчдын зөвлөгөөн-2022”

Малын ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээхийг зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлт малчдын ахуй амьдралд хэрхэн нөлөөлж байгаа, түүнийг хэрхэн эрсдэл багатай даван туулах, туршлага судлах малчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 05 ны өдөр Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд Засаг дарга, 4 мэргэжилтэн, 7 малчны хамт 12 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.



Гар худаг шинээр гаргах,сэргээн засварлахад мөнгөн урамшуулал олгох

Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах даац хамгаалах,иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Гар худаг шинээр гаргах,сэргээн засварлахад мөнгөн урамшуулал олгох ажлыг эрчимтэй хийж байгаа бөгөөд шаардлагатай материалыг бүрдүүлэн авч ажиллаж байна.

Өвөлжилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд

Өөрийн аймгийн бусад сумын нутагт өвөлжих, оторлох айл өрх, хүн ам , малын тоог 5 төрлөөр нь нарийвчлан гаргаж хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэв.



№	Төрөл	Хүн ам	Мал	Хүнс	Хөдөө аж ахуйн газар
1	Ажлаагүй	12	100	100	100
2	Ажлаагүй	12	100	100	100
3	Ажлаагүй	12	100	100	100
4	Ажлаагүй	12	100	100	100
5	Ажлаагүй	12	100	100	100
6	Ажлаагүй	12	100	100	100
7	Ажлаагүй	12	100	100	100
8	Ажлаагүй	12	100	100	100
9	Ажлаагүй	12	100	100	100
10	Ажлаагүй	12	100	100	100
11	Ажлаагүй	12	100	100	100
12	Ажлаагүй	12	100	100	100

Аймгийн засаг даргын захирамжийн дагуу аймаг сумдын аюулгүйн нөөцөд өвс тэжээл бэлтгэн нийлүүлэх чиглэлийн дагуу дарьганга сумын 1-р багийн иргэн Б.Батхүрэлтэй, сумын засаг дарга болон ХААТ гэрээ байгуулан сумын өвсний Фондод 4000 буюу 80 тн боодол өвс татан авахаас одоогийн байдлаар 633 буюу 15 тн өвсийг бэлтгэн нийлүүлээд байна. Малчдын гар дээр 500 тн өвс 30 тн гар тэжээл бэлтгэх зорилготой байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 сарын 20-ны өдрийн 06 дугаар албан даалгаврыг гарган хэрэгжилтийг хангуулан албан даалгавраар гарган хэрэгжилтийг тооцон 14 хоног тутамд ХХАА газарт мэдэгдэж байна.



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:

10 дугаар сарын 10-нд Засаг даргын тамгын газрын 17 албан хаагчдад Хөдөлмөрийн хууль, ХАБЭА-н тухай хууль, Оффисын ажилтны аюулгүй ажиллагаа сургалтуудыг хийж АХА тэмцээнийг явуулсан.



Гар урлал, автомашин засварын сургалтын зарыг ЗАР МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ НАРАН СУМ, Сүхбаатар аймгийн Наран сум группт тависан. 10 иргэнд мэдээлэл өгөн 4 иргэнийг сургалтанд бүртгэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох профайлинг үнэлгээг ажил хайгч 14, хувиараа хөдөлмөр эрхлэгч 3 нийт 17 иргэнд хийсэн.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж асаргаа сунгалт хийлгэх-5 иргэний, асаргаа шинээр тогтоолгох 1 иргэний асуудлыг хэлэлцсэн.

10 дугаар сарын 1-нд ахмадын баярын үйл ажиллагаанд оролцож сугалаа явуулж 2 ахмадыг ахмадын амралтанд амрах эрхийн бичгээр шагнасан. Байгууллагын харъяалалгүй 144 ахмадад 1440000 төгрөгийг дансанд олголт хийгдсэн.



10 дугаар сарын 6-нд ямаа төсөлд хамрагдсан 3 өрхөд ямааг хүлээлгэн өгсөн.

Иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа цаасаар 17 иргэнээс судалгаа аваад байна.

10 дугаар сарын 18-нд зорилтот



бүлгийн 16 иргэнд ЭМТ-тэй хамтран эрүүл мэндийн сургалт хийн үзлэг шинжилгээнд хамруулан дархлаа дэмжих багц олгосон.

*Өглөөний цайг өөрт эрүүл хооллолтын сургалт

*Эмийн зохистой хэрэглээ сургалт

*2022 онд зорилтот өрхөд хийсэн ажлын танилцуулга

*Цус, шээсний шинжилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг

*Дархлаа дэмжих багц олгох





10 дугаар сарын 20-нд аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын комиссын бүрэлдэхүүн ирж суманд ажилласан. Энэ үеэр сургууль цэцэрлэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрхөөр явсан.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Түүх соёлын дурсгалт газрын тооллогын ажлаар 1-р багийн нутаг гүн худаг багийн хийдийн туурь, Агуйтын хад, ганзай хад, морины зурагтай хад, 2-р багийн нутаг болох Молцогийн хийдийн туурь, Баяндулаан уулын агуй, Сайн худгийн хийдийн туурь, Гиваан толгой, Ноён хөндийн хүн чулуун хөшөө, 3-р багийн нутаг болох Наранбулгийн булш зэрэг 13 газарт тоолллого хийн бүртгэлжүүллээ.



“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, МУ-н ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөн, намрын мод тарих өдрийн хүрээнд сумын хэмжээнд улиас, хайлаас зэрэг 2 төрлийн 3124 ширхэг модыг шинээр тарьлаа. Уг ажилд 141 иргэн, 8 ААНБ оролцож 15.620.000 төгрөгийн зардал гаргасан.




“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслөөс зохион байгуулсан сургалтанд сумын засаг дарга, ХАА мэргэжилтэн, цаг уурч, Газрын даамал, 1,2-р багийн 7 малчин нийт 13 хүний бүрэлдхүүнтэйгээр хамрагдсан.



3-р багийн засаг даргатай хамтран сумын төвийн золбин нохой устгалын ажлыг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар 12 нохойг буудаж устгасан бөгөөд 250.000 төгрөгийн зардал гаргаад байна.



Байгалийн нөөц ашигласны албан татварын орлого зарлагын мэдээ БНАТ-1, БНАТ-2 мэдээг хэрхэн зөв шивэх тухай сургалтанд хамрагдаж сумын 2023 оны орлого, зарлагын мэдээг программд шивж үнэн зөв оруулсан.



1-р багийн иргэн С.Анхбаяраас ирсэн гомдлын дагуу Сумын 1-р багийн засаг даргатай хамт сумын нутаг дэвсгэрт буусан Онгон сумын 2 өрхөд бэлчээр чөлөөлөх тухай албан мэдэгдэл хүргүүлж ажиллаа. Мөн ойр орчмын хог хаягдлаа цэвэрлэх тухай шаардлага өгсөн.



НИЙТИЙН БИЕЙН ТАМИРИЙН ЧИГЛЭЛЭЭР:

2022 оны 10 сарын 11-нд Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан Д.Ариун-Эрдэнэ болон Бадмаараг охидын клубтэй хамтран Олон улсын охидын өдрийг тохиолдуулан зохион байгуулж буй үйл ажиллагаануудыг хамтран ажилласан.

1-ээс 5-р ангийн охидуудын дунд “Хөгжөөнт буухиа” тэмцээн



МӨН БАДМААРАГ ОХИДЫН КЛУБЫН ГИШҮҮДТЭЙ ХАМТРАН БЭЛТГЭЛ АЖИЛ ХИЙСЭН.

Сумын нийт төрийн албан хаагчдын Биеийн жингийн индекс тодорхойлох. Биеийн жингийн индекс тодорхойлсноор жингийн илүүдэлтэй байна уу, эсвэл дутагдалтай байна уу гэдгээ тодорхойлж өөрийн биед тохирох, дасгал хөдөлгөөн болон хоололтон дээрээ анхаарах гэх мэт олон давуу талтай юм.

Үүнд. Одоогийн байдлаар ЗДТГ, НАРХАН ЦЭЦЭРЛЭГ нар оролцсон байна.



2022 оны 10 сарын 18 нд сумын нийт 18-39 насны залуучуудын дунд сумын залуучуудын холбоотой хамтран сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулсан. Мөн энэхүү тэмцээнд маань Дарьганга сум, Онгон сумаас эрэгтэй эмэгтэй багууд ирж оролцсон. Тэмцээнд нийт:

-Наран сумаас эрэгтэй 6 баг, эмэгтэй 3 баг

-Дарьганга сумаас эрэгтэй 1 баг, эмэгтэй 1 баг

- Онгон сумаас эрэгтэй 2 баг эмэгтэй 1 баг тус тус оролцсон.



ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГ:

Сургалт хүмүүжлийн талаар

-Туслах багш нарын дунд үзүүлэх хичээл зохион байгуулагдсан бөгөөд бэлтгэл бүлгийн туслах багш Б.Ариунзул "Хог хаягдал ангилан ялгах" сэдвээр хичээл зааж хэлэлцсэн.

-Заах аргын нэгдлийн ахлагч туслах багш нарт "Шүлэг цээжлэх аргазүй"-н сургалтыг явуулсан бөгөөд ахлах бүлгийн хүүхдэд Түмэнжаргалын "Зүүдний байшин" шүлгийг цээжлүүлж арга туршлагаа хуваалцсан.

-Хувилбарт сургалтын хүүхдүүдийн эцэг эхтэй гэрээ байгуулахаар төлөвлөж, маршрутын дагуу айл өрхөөр явахад бэлэн болсон.

-Багш нарын баярыг угтан ЗАН-с зохион байгуулсан хамтын хичээлийг дунд бүлгийн багш Ч.Батцэцэгтэй хамтран туршилт танин мэдэхүйн чиглэлээр "Жүрж" жимс сэдвийн хүрээнд амжилттай явууллаа. Нийт 29 хүүхэд хамрагдсан. Харин багш Эрдэнэцэнгэл, Цэрэнлхам нар ахлах бүлэгт хөгжмийн хичээлийг заахад нийт 28 хүүхэд оролцсон.



-Бэлтгэл бүлгийн хүүхдүүдээс ХЭМ-ийн түвшинг хүч, тэнцвэр гэсэн 2 чадвараар авсан. Бүлгийн нийт 28 хүүхэд хамрагдсанаас хүчний чадвараар маш сайн-3, хангалттай-22, дэмжлэг үзүүлэх шаардлагатай-4 Тэнцвэрийн чадвараар маш сайн - 15, хангалттай -11, дэмжлэг үзүүлэх шаардлагатай-2 гэж үнэлэгдлээ. Үүнээс үзэхэд бүлгийн хүүхдүүд массаараа хангалттай гэж үнэлэгдсэн.



Хүүхэд хамгаалал

- Бүлгийн хүүхдүүдээс гэр- цэцэрлэг- гэр маршрутын зураглалыг авч явах замыг тодорхой болгон аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

-Өндөр эрсдэлтэй ахлах, бэлтгэл бүлгийн 4 хүүхдэд багш нартайгаа хамтран кейс нээсэн.

-Эцэг эхтэй харилцах дэвтэрийг нээж тухайн хүүхдийн сурсан зүйл болон харилцаа хандлага зэргийн талаар санал бодлоо солилцон ажиллаж байна.

-Хүүхэд хамгааллын самбарыг мэдээ мэдээллээр шинэчилсэн

-Бүлгүүдийн хүүхдүүдийн эрсдлийн үнэлгээ болон бусад судалгааг нэгтгэн сумын хамтарсан багт хүргүүлсэн.

-Өглөөний хүлээн авалт, орой тарах үед машинтай эцэг эхчүүдийн хараа хяналт суларч, зогсоолд зогсохгүйгээр зорчих нь эрсдэл үүссэн тул сумын цагдаагийн газартай хамтран “Цагдаа эцэг эх” ажлыг зохион байгуулж байна.



ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.БЯМБАСҮРЭН